


## **ЗАВХАН АЙМАГ: Малын зөөврийн хашааны техникийн тодорхойлолт**

**Зөөврийн хашаа нь хайс, хоолойвч, хаалга, бэхлэгч, явах анги хэсгээс бүрдэнэ.**


1. **Зөөврийн хашааны багтаамж** – Нэг удаад 800-1000 толгой бог багтана.
2. **Зөөврийн хашааны хайс** – 26 ширхэг
  - 2.1 Хайс нэг бүр нь 1,3 метрээс багагүй өндөртэй, 2 м урттай, хөнгөн, зэвэрдэггүй, чанар сайтай, бат бөх 25 мм-ээс багагүй голчтой труба, квадрат төмөртэй дүйцэхүйц төмөр материалаар хийгдсэн, угсарч зөөвөрлөхөд хялбар материалтай байна.
  - 2.2 Хайсны сараалж газраас дээш 20 см-ээс өндөргүй, доод талын 4 сараалжны хоорондын зай 13 см-ээс ихгүй, дээд талын 4 сараалжны хоорондын зай 18 см-ээс ихгүй байх бөгөөд малын эвэр, хөл завсраар нь орж гэмтэхээргүй 9 ширхэг төмрөөр гагнагдсан байна.
  - 2.3 Хайсны голоор 3 мм-ээс багагүй зузаантай 40 мм-ээс багагүй өргөн, 1,3 м өндөр плоса төмрөөр холбож бэхлэлт хийсэн байна.
  - 2.4 Хайс бүрийг холбож угсрахад хялбар холбоос түгжээтэй байна. Хайсыг холбох 2 талдаа тус тус 4 ширхэг сэнжтэй холбоостой байна. Холбоос төмрийн хэмжээ 1,3 м-ээс багагүй урттай, 15 мм-ээс багагүй диаметртэй байна.
3. **Хоолойвч, хаалга** – 6 ширхэг
  - 3.1 Мал гүйлгэх 2 м урт, 1,3 м өндөр хоолойвчтой, 1,2 м-ээс багагүй өргөн, 1,3 м өндөр 6 хаалгатай байна. Хоолойвчны доод хэсгийг 80 см-ээс багагүй өндөртэй 2 м урттай лист төмрөөр төмөрлөсөн байна.
  - 3.2 Хаалганы шон нь 40 мм квадрат төмөр хашааны өндөртэй ижил түвшинд хаалга тус бүрд 2 ширхэг áàéíà.
4. **Бэхлэгч** – 28 ширхэг
  - 4.1 Сараалжин хашаа бүрийг газартай хөдөлгөөнгүй бэхлэх бэхлэгчтэй байна. Бэхлэх гадасны тоо 28 ширхэгээс багагүй байна
5. **Явах анги** – 1 ширхэг
  - 5.1 Зөөврийн хашааны чиргүүлийн дугуй нь 185R15 хэмжээтэй шинэ дугуй байна. Чиргүүл нь 26 ш хайс, 6 ш хоолойвч, 6 хаалга бүхий зөөврийн хашааг бүхэлд нь хэвтээгээр болон босоогоор ачих багтаамж болон даацтай, бага оврын суудлын машинаар зөөвөрлөн явах боломжтой суурь, аралтай байна. Хавсралтад байгаа чиргүүлийн зурагтай дүйцэхүйц байж болно.
6. Гагнуурыг чанартай хийж гүйцэтгэн баталгаа өгсөн байна.
7. Бэхлэгчийг зоох лантуу, авах бродоктой байна.

**Жич: Техникийн тодорхойлолттой холбоотой лавлах зүйл байвал Завхан аймгийн Мал эмнэлгийн албаны дарга Энх-Амгалантай 98115298 дугаарын утсаар холбогдоно уу.**

ЗАВХАН АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН НЭГЖҮҮДЭД ЗОРИУЛАГДАН ХИЙГДЭХ БОГ МАЛЫН ЗӨӨВӨРИЙН ХАШААНЫ  
ПЛАН ЗУРАГ



## Хашааны хоолойны хаалга





**UNEGUI.MN**